

**БНХАУ-ын Цаг уурын албанаас зохион байгуулсан
"Конвекцийн аюултай цаг агаарыг хэт богино хугацаанд
урьдчилан мэдээлэх арга" сэдэвт цахим сургалтад
оролцсон товч тайлан**

2020.09.02

Дэлхийн цаг уурын байгууллагын санхүүжилтээр БНХАУ-ын Цаг уурын албанаас зохион байгуулагдаж буй сургалт нь 2020 оны 08-р сарын 17-с 28-ны хооронд болсон ба уг сургалт COVID-19 цар тахлын улмаас цахим хэлбэрээр зохион байгуулагдаж буйгаараа онцлог юм.

Энэхүү сургалтын гол зорилго хүчтэй конвекцын улмаас үүсэх гамшигийг бууруулах, түүнийг радарын бүтээгдэхүүн болон нарийнчлал сайтай тоон загварын үр дүнг ашиглан богино хугацаанд илрүүлж урьдчилан мэдээлэх аргыг сайжруулахад оршино.

Сургалт БНХАУ-ын Цаг уурын албаны <http://mooc.cmatc.cma.cn/-p> сайтанд байршуулсан хичээлийн программын дагуу өдөр бүр үзэх хичээл нь тухайн өдрөө автоматаар нээгдэх зарчмаар бэлдсэн pdf болон слайд нь тайлбарын хамт тавигдаж байсан. Мөн хичээлийн дараа бататгах асуулт, хариулт болон багшийн үнэлгээний системтэй, олон орны мэргэжил нэгт нөхөдтэй танилцах, харилцан туршлага солилцох нүүр хагарах өрөөтэй г.м олон төрлийн сайжруулалт хийх үнэлгээний системтэй байлаа.

Сургалтын өдрүүдэд:

2020.08.17-18-нд БНХАУ-ын Цаг уурын албаны өнөөгийн байдал, бүтэц, бүрэлдэхүүн, зохион байгуулалт, цаг уурын хөгжил, олон улсын хамтын ажиллагааны талаар танилцуулга,

2020.08.19-нд Радарын үйл ажиллагаа түүний ерөнхий зарчим, радарт илрэх үүл, үүлний долгион, халуун орны циклоны долгион, цаг уурын бус долгион, конвектив шуурга, хүчтэй конвекцын үзэгдлийн тухай,

2020.08.20-24-нд Аадар бороо, аянга цахилгаантай аадар бороо болон аянга буух нөхцөлийг доплер радар дээр илрүүлэх, аюултай цаг агаарыг хэрхэн тодорхойлох, олон тохиолдлуудад радарын бүтээгдэхүүнээр өөр өөр цаг агаарыг тодорхойлох, мөндөр, хүчтэй салхи, хар салхи, гэнэтийн үерийг тодорхойлох тухай,

2020.08.25-нд Fengyun хиймэл дагуулын тухай болон ирээдүйн төлөвлөгөө, конвекцын үүлийг FY хиймэл дагуулаар таних, шилжилт, усан болон хуурай газрын илрүүлэлтийн тухай,

2020.08.26-нд Хүчтэй конвекцын цаг агаарыг урьдчилан мэдээлэх, орон нутгийн онцлогоор хүчтэй конвекцыг илрүүлэх, тоон загварын үр дүнг ашиглах,

БНХАУ-ын Цаг уурын хэт богино хугацааны болон маш богино хугацааны урьдчилсан мэдээний тухай,

2020.08.27-нд БНХАУ-ын цаг уурын өндөр нарийвчлалтай тоон загваруудын товч танилцуулга, параметрийн нөлөөлөл, хил хязгаарын нөхцлүүдийн тухай ойлголтууд болон өндөр таарцтай тоон загварыг янз бүрийн хүчтэй конвекцид ашиглах,

2020.08.28-нд Хаврын сүүл, зуны эхээр Өмнөд Хятадын баруун хэсэгт хүчтэй конвектив цаг агаартай байдаг ба үүний орон зай, цаг хугацааны тархалтын шинж чанарыг тодорхойлсон жишээн дээр хүчтэй конвекц үүсэх таатай нөхцлийг байгаль орчны томоохон цар хүрээгээр харуулсан ба түүний эдийн засаг, амьдрах орчинд нөлөөлөх нөлөөллийн талаар,

2020.08.31-нд БНХАУ-ын соёл, ёс, заншил, тэмдэглэлт өдрүүд болон түүний утга учрын тухай хичээлүүд заагдсан.

Дүгнэлт:

Хүчтэй конвекцээс үүссэн гамшиг нь цаг уурын бүх гамшгийн ихэнх хувийг эзэлдэг. Богино хугацаанд орсон аадар борооны улмаас үер бууж, хүчтэй бороо, мөндөр, хар салхи зэрэг аюултай болон гамшигт үзэгдлийн улмаас хүмүүсийн эд хөрөнгө, амь насанд ихээхэн хэмжээний хохирол үзүүлж байна. Ийм аюултай үзэгдлийг урьдчилан мэдээлэхэд уур амьсгалын өөрчлөлт ихтэй өнөө үед бэрхшээлтэй байгаа хэдий ч орчин үеийн техник, технологийн хөгжил, хиймэл дагуулын бүтээгдэхүүн, радарын бүтээгдэхүүн, зөв ажиглалтын мэдээ, орон нутгийн цаг агаарын онцлог, нарийвчлал, таарц сайтай тоон загварын үр дүн г.м-ийг ашиглан богино хугацаанд аюултай болон гамшигт үзэгдлийг мэдээллэж байна.

Үзэгдлийг таарц сайтай, үнэн зөв мэдээлэх нь олон төрлийн эрсдлээс хамгаалах, бууруулах ач холбогдолтой бөгөөд эрт илрүүлэх талаар маш их хэмжээний судалгаа, шинжилгээний ажил хийгдэж байна гэж дүгнэж байна.

Тайлан бичсэн:

Синоптик инженер

Ц.Баярмаа

Ц.Баярмаа